БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2021/145/СТА-ТШЗ


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Глобал капитал аудит ХХК Аудитор: С.Сарантуяа

Утас: 99449299 Цахим хаяг: Sarantuya@gmail.com


Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ... 8

3.Аудитын тайлан ... 11

3.1. Ерөнхий зүйл ... 11

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ... 11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ... 11

3.4. Материаллаг байдал ... 12

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ... 12

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ... 13

3.7. Шилэн дансны мэдээлэл ... 14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 15

3.9. Аудитын илрүүлэлт ... 15

Залруулсан алдаа ... 15

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ... 15

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/83

танай ____________ -ны №______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г. ЭНХБАЯР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн ЭМГ, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргасан байна. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй эмнэлгүүдтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, ажил үйлчилгээний чанарын асуудлыг тухайн шатны засаг дарга хэрэгжүүлдэг.

Тус байгууллага нь Ковид-19 цар тахлын онцгой дэглэмийн үед Аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн газраас өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

2021 А4 ТООТ

005020040

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 46,014,975.11 | 58,728,143.88 |
| 33 | АВЛАГА | 4,446,596.22 | 798,182.42 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 328,763.00 |
| 335 | Бусад авлага | 4,446,596.22 | 469,419.42 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,446,596.22 | 469,419.42 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 41,568,378.89 | 57,929,961.46 |
| 351 | Түүхий эд материал | 8,908,820.00 | 22,160,602.57 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,808,000.00 | 10,417,089.00 |
| 35130 | Эм боох материал | 1,100,820.00 | 11,743,513.57 |
| 354 | Хангамжийн материал | 31,839,558.89 | 34,949,358.89 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,172,490.00 | 1,172,490.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,456,400.00 | 3,371,200.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 800,000.00 | 800,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 1,000,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 67,700.00 | 67,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 28,342,968.89 | 28,537,968.89 |
| 35600 | Мал амьтад | 820,000.00 | 820,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 655,296,556.37 | 652,456,474.83 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 655,296,556.37 | 652,456,474.83 |
| 392 | Биет хөрөнгө | 647,016,556.37 | 644,176,474.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 608,334,763.00 | 606,350,893.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -22,921,619.66 | -47,512,905.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,360,352.00 | 36,360,352.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,449,852.00 | -18,413,852.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 81,863,110.08 | 87,567,110.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -59,617,801.94 | -67,358,718.21 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,963,019.50 | 52,060,019.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,164,997.70 | -13,461,007.45 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,600,000.00 | 12,600,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,950,416.91 | -4,015,416.91 |
| 393 | Биет бус хөрөнгө | 8,280,000.00 | 8,280,000.00 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -650,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,280,000.00 | 8,280,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 701,311,531.48 | 711,184,618.71 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 423,133.50 | 12,758,303.15 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 423,133.50 | 12,758,303.15 |
| 413 | Өглөг | 423,133.50 | 12,758,303.15 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 257,481.00 | 7,433,237.45 |
| 4136 | Бусад өглөг | 165,652.50 | 5,325,065.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 165,652.50 | 5,325,065.70 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 700,888,397.98 | 698,426,315.56 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 700,888,397.98 | 698,426,315.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 734,316,565.92 | 734,316,565.92 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 734,316,565.92 | 734,316,565.92 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -239,125,825.24 | -240,322,183.66 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -239,125,825.24 | -237,860,101.24 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -2,462,082.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 205,697,657.30 | 204,431,933.30 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 701,311,531.48 | 711,184,618.71 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 440,093,862.00 | 460,822,343.27 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 71,522,132.00 | 55,920,443.27 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 71,522,132.00 | 55,920,443.27 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71,522,132.00 | 55,920,443.27 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 71,522,132.00 | 55,920,443.27 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 368,571,730.00 | 404,901,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 332,147,800.00 | 342,849,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 39,700.00 | 16,174,540.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,700.00 | 16,174,540.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,298,600.00 | 24,093,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,298,600.00 | 24,093,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 11,085,630.00 | 21,784,560.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,239,310.00 | 21,784,560.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 393,755,173.99 | 462,070,076.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 393,755,173.99 | 462,070,076.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 391,091,511.46 | 448,993,686.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,827,481.00 | 263,606,176.20 |
| 210101 | Үндсэн цалин | 210,121,928.00 | 248,823,800.20 |
| 210102 | Нэмэгдэл | 18,158,564.00 | 5,549,098.00 |
| 210104 | Урамшуулал | 6,546,989.00 | 9,233,278.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,339,928.12 | 33,162,836.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,202,502.12 | 22,495,115.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,250,576.00 | 2,666,930.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,880,815.00 | 2,133,543.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 416,982.00 | 533,386.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,589,053.00 | 5,333,860.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,894,171.00 | 19,207,874.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,271,612.00 | 2,851,282.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,413,239.00 | 16,256,592.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 209,320.00 | 100,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,304,283.00 | 34,761,132.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,643,650.00 | 1,314,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,541,233.00 | 29,976,532.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,323,300.00 | 1,470,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,789,600.00 | 1,999,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 40,270,333.28 | 44,845,230.70 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,768,933.28 | 38,505,230.70 |
| 210502 | Хоол, хүнс | 7,996,400.00 | 6,340,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 36,900.00 | 660,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,900.00 | 660,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 84,000.00 | 1,046,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 84,000.00 | 1,046,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 439,700.00 | 790,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,700.00 | 39,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 751,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,894,715.06 | 50,913,737.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,268,900.00 | 7,487,005.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,663,662.53 | 13,076,389.91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 846,320.00 | 8,004,840.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 8,004,840.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 964,894.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 964,894.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,817,342.53 | 4,106,655.91 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,817,342.53 | 4,106,655.91 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 46,338,688.01 | -1,247,733.20 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 4,588,487.93 | 1,214,349.22 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,588,487.93 | 1,214,349.22 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -4,588,487.93 | -1,214,349.22 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 41,750,200.08 | -2,462,082.42 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 368,571,730.00 | 404,901,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 368,571,730.00 | 404,901,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 332,147,800.00 | 342,849,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 332,147,800.00 | 342,849,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 39,700.00 | 16,174,540.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,700.00 | 16,174,540.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,298,600.00 | 24,093,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон | 25,298,600.00 | 24,093,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 11,085,630.00 | 21,784,560.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,239,310.00 | 21,784,560.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 368,571,730.00 | 404,901,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 368,571,730.00 | 404,901,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 365,908,067.47 | 391,825,510.09 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,143,712.35 | 259,435,322.49 |
| 210101 | Үндсэн цалин | 173,736,200.00 | 189,108,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,947,212.35 | 54,809,905.77 |
| 210104 | Урамшуулал | 13,460,300.00 | 15,516,816.72 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,880,574.12 | 30,486,696.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,545,770.12 | 20,292,358.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,407,992.00 | 2,665,985.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,742,798.00 | 1,782,443.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 489,500.00 | 522,337.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,694,514.00 | 5,223,572.30 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,925,771.00 | 22,128,306.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,271,651.00 | 2,851,282.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,413,200.00 | 19,062,024.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,920.00 | 215,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,224,833.00 | 33,131,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,541,233.00 | 27,171,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,516,000.00 | 1,565,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,967,600.00 | 2,166,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 1,028,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 40,545,027.00 | 22,539,980.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,140,527.00 | 13,576,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,899,500.00 | 6,258,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,505,000.00 | 2,705,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,911,700.00 | 6,850,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,574,800.00 | 5,850,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,936,900.00 | 1,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 84,000.00 | 1,046,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 84,000.00 | 1,046,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 439,700.00 | 8,920,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,700.00 | 8,169,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 751,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,752,750.00 | 7,287,005.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,752,750.00 | 7,287,005.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,663,662.53 | 13,076,389.91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 846,320.00 | 8,004,840.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 8,004,840.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 435,929.00 | 964,894.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 435,929.00 | 964,894.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,381,413.53 | 4,106,655.91 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,381,413.53 | 4,106,655.91 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд сан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 734,316,565.92 | 207,401,008.30 | -287,012,243.32 | 00.00 | 654,705,330.90 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,703,351.00 | 00.00 | 1,703,351.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 734,316,565.92 | 207,401,008.30 | -285,308,892.32 | 00.00 | 656,408,681.90 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 41,750,200.08 | 00.00 | 41,750,200.08 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 734,316,565.92 | 205,697,657.30 | -239,125,825.24 | 00.00 | 700,888,397.98 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 734,316,565.92 | 205,697,657.30 | -239,125,825.24 | 00.00 | 700,888,397.98 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,265,724.00 | 00.00 | 1,265,724.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 734,316,565.92 | 205,697,657.30 | -237,860,101.24 | 00.00 | 702,154,121.98 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,265,724.00 | 00.00 | 00.00 | -1,265,724.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -2,462,082.42 | 00.00 | -2,462,082.42 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 734,316,565.92 | 204,431,933.30 | -240,322,183.66 | 00.00 | 698,426,315.56 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |

| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 391,716,600.00 | 383,655,810.09 | 8,060,789.91 | 97.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 391,716,600.00 | 383,655,810.09 | 8,060,789.91 | 97.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 391,716,600.00 | 383,655,810.09 | 8,060,789.91 | 97.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,155,900.00 | 259,435,322.49 | 1,720,577.51 | 99.3 |
| 210101 | Үндсэн цалин | 189,108,600.00 | 189,108,600.00 | 0 | 100 |
| 210102 | Нэмэгдэл | 55,913,900.00 | 54,809,905.77 | 1,103,994.23 | 98 |
| 210104 | Урамшуулал | 16,133,400.00 | 15,516,816.72 | 616,583.28 | 96.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,809,200.00 | 30,486,696.60 | 2,322,503.40 | 92.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,279,700.00 | 20,292,358.00 | 1,987,342.00 | 91.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,666,100.00 | 2,665,985.15 | 114.85 | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,096,900.00 | 1,782,443.32 | 314,456.68 | 85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 524,200.00 | 522,337.83 | 1,862.17 | 99.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,242,300.00 | 5,223,572.30 | 18,727.70 | 99.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,293,200.00 | 22,128,306.00 | 164,894.00 | 99.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,550,000.00 | 2,851,282.00 | -301,282.00 | 111.8 |
| 210302 | Түлш, халаалт | 19,413,200.00 | 19,062,024.00 | 351,176.00 | 98.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 215,000.00 | 115,000.00 | 65.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,258,900.00 | 33,131,500.00 | 127,400.00 | 99.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,200,000.00 | 0 | 100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,298,500.00 | 27,171,100.00 | 127,400.00 | 99.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,565,300.00 | 1,565,300.00 | 0 | 100 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,166,300.00 | 2,166,300.00 | 0 | 100 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,028,800.00 | 1,028,800.00 | 0 | 100 |
| 2105 | Нормативт зардал | 25,330,800.00 | 22,539,980.00 | 2,790,820.00 | 89 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,325,800.00 | 13,576,980.00 | 2,748,820.00 | 83.2 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,258,000.00 | 42,000.00 | 99.3 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,705,000.00 | 2,705,000.00 | 0 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,650,000.00 | 6,850,000.00 | 800,000.00 | 89.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,850,000.00 | 5,850,000.00 | 0 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,000,000.00 | 800,000.00 | 55.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,144,000.00 | 1,046,000.00 | 98,000.00 | 91.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,144,000.00 | 1,046,000.00 | 98,000.00 | 91.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 850,000.00 | 751,000.00 | 99,000.00 | 88.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7224600 | 7287005 | -62,405.00 | 100.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,224,600.00 | 7,287,005.00 | -62,405.00 | 100.9 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 391,716,600.00 | 383,655,810.09 | 8,060,789.91 | 97.9 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 342,849,600.00 | 338,742,944.09 | 4,106,655.91 | 98.8 |
| 131007 | Тусгай зориулалтын | 342,849,600.00 | 338,742,944.09 | 4,106,655.91 | 98.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шилжүүлгээс санхүүжих | | | | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 24,093,200.00 | 23,128,306.00 | 964,894.00 | 96 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 24,093,200.00 | 23,128,306.00 | 964,894.00 | 96 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 24,773,800.00 | 21,784,560.00 | 2,989,240.00 | 87.9 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 24,773,800.00 | 21,784,560.00 | 2,989,240.00 | 87.9 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0 | 0 | 0 | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 17 | 0 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | 0 | |
| 620004 | Гэрээт ажилтан | 0 | 0 | 0 | |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | 84 | 64 | 20 | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0 | 0 | 0 | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч | 1 | 1 | 0 | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч | 17 | 17 | 0 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 5 | 5 | 0 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 16,174,540.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 16,174,540.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 8,169,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 8,169,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 8,169,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 8004840.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 8,004,840.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 8,004,840.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 16174540.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 16,174,540.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 16,174,540.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв ийн дарга Г.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 24–ний хооронд Баянхонгор аймаг дахь Глобал Капитал аудит ХХК-ны газрын аудитор С.Сарантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дүгээр сарын 27-ны өдрийн 83 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Мэргэшсэн эвсэг хамт олны оролцоотойгоор, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг аюулгүй, эрсдэлгүй орчинд, чанартай үзүүлж өвчлөл эндэгдлийг тууштай бууруулна гэсэн зорилтыг дэвшүүлэн тодорхойлон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 393064.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7861.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 463585.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9271.7 мянган төгрөгөөр тооцов.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 711184,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 9873,1 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 46,015.0 | 58,728.1 | 12,713.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 4,446.6 | 798.2 | (3,648.4) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 41,568.4 | 57,930.0 | 16,361.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 655,296.6 | 652,456.5 | (2,840.1) |
| Үндсэн хөрөнгө | 764,051.2 | 803,668.4 | 39,617.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (108,754.7) | (151,211.9) | (42,457.2) |
| **Нийт хөрөнгө** | 701,311.5 | 711,184.6 | 9,873.1 |
| Өр төлбөр | 423.1 | 12,758.3 | 12,335.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 700,888.4 | 698,426.3 | (2,462.1) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 701,311.5 | 711,184.6 | 9,873.1 |

Бараа материалын дансны үлдэгдэл 57930,0 мянган төгрөг болж 16361,6 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн дансны үлдэгдэл өмнөх оноос 10642.6 мянган төгрөгөөр нэмэгдэж цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор 7260.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 3382.5 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 803668,4 мянган төгрөг болж 41801.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5704.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар тогтоолоор 1983,8 мянган төгрөгийн автограшийг дуудлага худалдаанд оруулж Х.Тунгалаг худалдан авсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад Баянхөх толгой ХХК-аас эмнэлгийн тоног төхөөрөмж 34597,0 мянган төгрөг, Иргэн Ганбатаас хүүхдийн өрөөний тохижилтод 1500,0 мянган төгрөг, нийт 36097.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй нийлүүлснийг санхүүгийн тайланд бүртгэж баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 698426,9 мянган төгрөг болж 2462.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2462.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 460822.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 20728.5 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 20728,5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 19301,8 мянган төгрөгөөр Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 16174,5 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын 3 жилийн тэтгэмж 8004,8 мянган төгрөг, өөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 462070,0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 68314,9 мянган төгрөгөөр буюу 1,17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 435502,9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 435502,9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43786,3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хасаж 391716,6 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төлөвлөгөөг 1 удаа тодотгол хийж 391716,6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391716,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 342849,6 мянган төгрөгийг улсын төсвөөс 24773,8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 3806,5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **НИЙТ** | **391,716,600.00** | **383,655,810.09** | **8,060,789.91** | **100.03** |
| **Хөтөлбөр71602** | **Шинэжинст ЭМТ** | | | | |
| **81603** | **Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ** | **261,155,900.00** | **259,435,322.49** | **1,720,577.51** | **99.34** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,155,900.00 | 259,435,322.49 | 1,720,577.51 | 99.34 |
| 210101 | Үндсэн цалин | 189,108,600.00 | 189,108,600.00 | - | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 55,913,900.00 | 54,809,905.77 | 1,103,994.23 | 98.03 |
| 210104 | Урамшуулал | 16,133,400.00 | 15,516,816.72 | 616,583.28 | 96.18 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,809,200.00 | 30,486,696.60 | 2,322,503.40 | 92.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,279,700.00 | 20,292,358.00 | 1,987,342.00 | 91.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,666,100.00 | 2,665,985.15 | 114.85 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 2,096,900.00 | 1,782,443.32 | 314,456.68 | 85.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 524,200.00 | 522,337.83 | 1,862.17 | 99.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,242,300.00 | 5,223,572.30 | 18,727.70 | 99.64 |
| **80109** | **ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал** | **22,293,200.00** | **22,128,306.00** | **164,894.00** | **99.26** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,293,200.00 | 22,128,306.00 | 164,894.00 | 99.26 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 2,550,000.00 | 2,851,282.00 | (301,282.00) | 111.81 |
| 210302 | Түлш, халаалт | 19,413,200.00 | 19,062,024.00 | 351,176.00 | 98.19 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 215,000.00 | 115,000.00 | 65.15 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,258,900.00 | 33,131,500.00 | 127,400.00 | 99.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 27,298,500.00 | 27,171,100.00 | 127,400.00 | 99.53 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,565,300.00 | 1,565,300.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а | 2,166,300.00 | 2,166,300.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,028,800.00 | 1,028,800.00 | - | 100.00 |
| **80302** | **Нэг иргэнд ноогдох нормативаар** | **25,330,800.00** | **22,539,980.00** | **2,790,820.00** | **88.98** |
| 2105 | Нормативт зардал | 25,330,800.00 | 22,539,980.00 | 2,790,820.00 | 88.98 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,325,800.00 | 13,576,980.00 | 2,748,820.00 | 83.16 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,258,000.00 | 42,000.00 | 99.33 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 7,650,000.00 | 6,850,000.00 | 800,000.00 | 89.54 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,850,000.00 | 5,850,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,000,000.00 | 800,000.00 | 55.56 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,144,000.00 | 1,046,000.00 | 98,000.00 | 91.43 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,144,000.00 | 1,046,000.00 | 98,000.00 | 91.43 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 850,000.00 | 751,000.00 | (8,070,700.00) | 1,049.49 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х | - | | | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 850,000.00 | 751,000.00 | 99,000.00 | 88.35 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,224,600.00 | 7,287,005.00 | (62,405.00) | 100.86 |

/Эх сурвалж: 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн газраас ажилчдын 3 жилийн тэтгэмжийн санхүүжилт 8044,5 мянган төгрөг мөн тайлант хугацаанд сарын мэдээнд эмийн өглөгийг барагдуулахаар 8130,0 мянган төгрөгийг тодотгож өгсөн, нийт 16174,5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зориулалтын дагуу зарцуулсан.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 85 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан байна. Аймгийн СХАА-аас нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас 65 мэдээ хугацаа хоцорч мэдээлэгдсэн төлөвт шилжсэн байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 6 | 1 | 4 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | | 4 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | | 4 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 20 | 16 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 52 | 44 | |
| | Нийт | 27 | 151 | 85 | 65 | 4 |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 6 зөвлөмжийн 4 зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлж, 2 зөвлөмж биелэгдээгүй 75 хувийн биелэлттэй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2405,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 2405.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 4 заалт бүхий зөвлөмж өгөв.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

***1.1 Илрүүлэлт:*** Тайлант онд нягтлан бодогч 1-р сарын шатахууны 2405,0 мянган төгрөгийн орлогыг шууд зардлаар бүртгэж бичилт хийснээс нярвын тайлангаас зөрүүтэй байсныг залруулж бүртгэв.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 2405,0 мянган төгрөгийн шатахууны орлого авч зарлагыг бараа материалын дансанд бүртгэж залруулга хийв.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 16128.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Аймгийн ЭМГ-аас тайлант онд 17052,3 мянган төгрөгийн тендерийн эмийг үнэ төлбөргүй нийлүүлсэн ба тайлант оны эцэст сумын ЭЭС-д 8004,2 мянган төгрөгийн эм байгааг тус байгууллага хүлээн аваагүй тул тайланд тусгаагүй иймд тухайн байгууллагад үлдэгдлээр байгаа эмийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

Мөн санхүүжилтийг хугацаанд нь авч цалингийн зардал, байгууллага хоорондын тооцоог цаг тухай бүрт баталгаажуулж , өр авлагыг барагдуулах, өр авлага үүсгэхгүй байх талаар дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## 4. Менежментийн захидал

*Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:*

***1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал***

***1.1 Илрүүлэлт:*** *Тухайн байгууллага нь цалин НДШ-ийн зардлыг 4043,1 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн ба тайланд онд өглөг 7325,7 мянган төгрөг ХХОАТ,ҮЭ-ийн өглөг байгаа нь төсвийг 3282,6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчсөн.*

*1.2. Эрсдэл: Төсвийн үр ашиг буурч, зарлага нэмэгдэх*

*1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а-д "тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж санхүүжилтийг хугацаанд нь авч цалингийн зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулж, өр авлагыг барагдуулах.*

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2.1 Илрүүлэлт:*** *Тайлан онд эмийн зардлыг 2790,8 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн ба оны эцэст эмийн 5305,0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байгаа нь 2514,2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн харагдаж байна. Энэ нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагад цаг хугацаанд нь эмийн тооцоог бүрэн хийж өглөгийг барагдуулаагүйтэй холбоотой байна. Мөн ЭМГ-аас 16308,3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм олгосон ба сумын ЭЭС нь ЭМТ-д захиалгын дагуу өгч, оны эцэст сумын ЭЭС-д 8004,2 мянган төгрөгийн эм байгааг ЭМТ орлого аваагүй тул тухайн үлдэгдлийг эмийн санч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчсөн.*

*2.2. Эрсдэл: Төсвийг зориулалт бус зарцуулж, үр ашгийн дээшлүүлэх.*

*2.3 Өгсөн зөвлөмж: Эмийн тооцоог тухай бүр нь тооцоо нийлж баталгаажуулж, сумын ЭЭС-д байгаа эмийн үлдэгдлийг хүлээн авч шаардлагатай нөхцөлд бусад ЭМТ болон ЭМГ-т хандаж эмийн солилцоо хийж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.*

***3.1 Илрүүлэлт:*** *Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 85 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 11 төрлийн 1 мэдээлэл, хагас жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, сараар байршуулах 36 төрлийн 16 мэдээлэл, тухай бүр байршуулах 96 төрлийн 44 мэдээлэл, нийт 65 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.*

*Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.*

*3.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй*

*3.1.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.*

*3.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***4.1 Илрүүлэлт:*** *Тайлант онд НДШ-ээс 328,7 мянга, урьд оны эмийн авлагын үлдэгдлээс 469,4 мянган төгрөгийн авлагатай гарч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчсөн.*

*1.2. Эрсдэл: Төсвийн үр ашиг буурч, зарлага нэмэгдэх*

*1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4..8 дахь заалтад тусгасан үүргээ төсвийн захирагч хэрэгжүүлэн, төрийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн авлагыг барагдуулж ажиллах.*

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

*АУДИТЫН ТАЙЛАНГ:*

*Бэлтгэсэн:*

*АУДИТОР ........................................................ С.САРАНТУЯА*
*Огноо: 2021.02.25*

*Анхан шатанд хянасан:*

*ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР........................................................А.ЦЭЭНЯМ*
*Огноо: 2021.02.25*

*Хоёр дахь шатанд хянасан:*

*ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР........................................................Б.МӨНХБАТ*
*Огноо: 2021.02.25*

6417143544
БНА0067 9007423

## 5. Хавсралт:Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/145/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 85 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 11 төрлийн 1 мэдээлэл, хагас жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, сараар байршуулах 36 төрлийн 16 мэдээлэл, тухай бүр байршуулах 96 төрлийн 44 мэдээлэл, нийт 65 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Г.Энхбаяр Н.Нямдорж |
| 2 | Санхүүгийн тайланд халаалтын өглөг оны эхэнд тусгаагүй байхад 2020.02.18-ны өдөр "Марал гүн" ХХК-д 44021.7 мянган төгрөгийг өмнөх онуудын халаалтын төлбөрийн үлдэгдэл гэж тайлант хугацааны зардал дээр нэмж шилжүүлсэн бөгөөд энэ нь баримтаар нотлогдохгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав. | 2405,0 | Санхүүгийн тайланд авлагаар залруулах | Дарга Нягтлан бодогч | Г.Энхбаяр Н.Нямдорж |
| 3 | Тухайн байгууллага нь цалин НДШ-ийн зардлыг 4043,1 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн ба тайланд онд өглөг 7325,7 мянган төгрөг ХХОАТ,ҮЭ-ийн өглөг байгаа нь төсвийг 3282,6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. | 3282,6 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Г.Энхбаяр Н.Нямдорж |
| 4 | Тайлан онд эмийн зардлыг 2790,8 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн ба оны эцэст эмийн 5305,0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байгаа нь 2514,2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн харагдаж байна. Энэ нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагад цаг хугацаанд нь эмийн тооцоог бүрэн хийж өглөгийг барагдуулаагүйтэй холбоотой байна. Мөн ЭМГ-аас 16308,3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм олгосон ба сумын ЭЭС нь ЭМТ-д захиалгын | 12047,3 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Г.Энхбаяр Н.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | дагуу өгч, оны эцэст сумын ЭЭС-д 8004,2 мянган төгрөгийн эм байгааг ЭМТ орлого аваагүй тул тухайн үлдэгдлийг эмийн санч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна | | | | |
| 5 | НДШ-ээс 328,7 мянга, урьд оны эмийн авлагын үлдэгдлээс 469,4 мянган төгрөгийн авлагатай | 798,1 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Г.Энхбаяр Н.Нямдорж |
| **ДҮН** | | **18533,0** | | | |